

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ИЛТГЭХ ХУУДАС

Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай

2024 оны 12 дугаар сарын 11

Улаанбаатар хот

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх үндэслэл

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам", Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг тус тус үндэслэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн төлөвлөгөөт ажил, дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулан холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулахад оршино.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан журмын холбогдох заалтыг үндэслэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг дараах үнэлгээний аргачлалаар үнэлэв.

$$\text{Хэрэгжилт} = \frac{\text{Хүрсэн түвшин} - \text{Суурь түвшин}}{\text{Зорилтот түвшин} - \text{Суурь түвшин}} \cdot 100\%$$

"Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3.1-6.2.3.4 дэх заалтын дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дараах үнэлгээгээр үнэлсэн болно.

- **"Үр дүнтэй"**- зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь;

- **"Тодорхой үр дүнд хүрсэн"**- зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70-100 хүртэл хувь;

- **"Эрчимжүүлэх шаардлагатай"**- зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх, зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай бол 30-70 хүртэл хувь;

- **"Үр дүнгүй"**- зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0-30 хүртэл хувь.

Дөрөв. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг хариуцсан хэлтэс, албан тушаалтнаас цаасан суурьтайгаар хүлээн авч, холбогдох хууль тогтоомжийг үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж ажилласан болно.

Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 хэсэг, 16 зорилго, 213 ажил, арга хэмжээг хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнан ажилласан байна.

Төлөвлөсөн 213 ажил, арга хэмжээг тайлагнасан байдалд аргачлалын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд:

1. Үр дүнтэй буюу 100% гүйцэтгэлтэй 163 ажил арга хэмжээ
2. Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99 хүртэл хувийн гүйцэтгэлтэй 25 ажил арга хэмжээ
3. Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69 хүртэл хувийн гүйцэтгэлтэй 15 арга хэмжээ
4. Үр дүнгүй болон үнэлэх боломжгүй буюу 0-30 хүртэл хувийн гүйцэтгэлтэй 3 арга хэмжээ байна.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын 2024 оны жилийн эцсийн байдлаар тайлагнасан 213 ажил, арга хэмжээг журамд нийцүүлэн үнэлэхэд үнэлгээний дундаж 88,3 хувийн хэрэгжилттэй байна.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг агуулга, зорилт, арга хэмжээ тус бүрээр нь тооцон гаргахад:

№	Агуулга	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь			Хувь
				100	90-30	0	
1	БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	6	98	77	18	3	88,1
2	ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	2	21	16	5	-	91,9
3	ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	6	56	46	10	-	96,0
4	ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ	9	40	34	6	-	92,6
Дүн		23	213	173	42	3	88,3

Тав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний дүгнэлт

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам", Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны "Аргачлал, загвар батлах тухай" 100 дугаар тушаалыг тус тус үндэслэн Засаг даргын Тамгын газрын гүйцэтгэлийн төлөвлөгөөний 4 хэсэг, 16 зорилго, 213 ажил, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд:

1.Тайлагнасан 213 ажил, арга хэмжээг холбогдох журамд нийцүүлэн үнэлэхэд үнэлгээний дундаж 88,3 хувийн гүйцэтгэлтэй буюу "Тодорхой үр дүнд хүрсэн" гэж үнэлэгдэж байна.

2. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ 88,1%, Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн үндсэн чиг үүргийн хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээ 91,9%, Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ 96,0%. Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилт, арга хэмжээ 92,6%-ийн хэрэгжилттэй байна.

3. Нийт 213 ажил, арга хэмжээнээс зорилтод түвшиндээ бүрэн хүрсэн, үр дүн гарсан 100%-тай 173 арга хэмжээ, зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан, холбогдох байгууллагын шийдвэр гарсан, гол үр дүн гарч байгаа 30-90 хувийн гүйцэтгэлтэй 40 арга хэмжээ, арга хэмжээ, үр дүнгүй буюу үнэлэх боломжгүй 0 хувийн гүйцэтгэлтэй 3 арга хэмжээ тус тус байна.

Үр дүнгүй буюу үнэлэх боломжгүй “0” хувийн гүйцэтгэлтэй 3 ажил:

1	1.1.1. Гамшгаас хамгаалах хуулийн хүрээнд хариу арга хэмжээг зохион байгуулна.	Засаг даргын нөөц	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	2024 оны байдлаар "Ковид 19" өвчний тохиолдол бүртгэгдээгүй ба эрүүл мэндийн байгууллагуудын гамшгийн төлөвлөгөөнд тодотгон ажиллаж байна. Нийслэлийн Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны А/90 дугаар тушаалын хүрээнд эрүүл мэндийн байгууллагууд бэлэн байдлаа ханган, гамшгийн төлөвлөгөөнд тодотгол хийн ажиллаж байна.	ҮБ	0
2	2.2.4. Нийслэл дүүргийн Тамгын газруудын албан хаагчдын дунд зохион байгуулагддаг "Спорт наадам-2024" тэмцээн уралдаанд оролцох	20 сая Дүүргийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувь	90	100	Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр нийслэл, дүүргийн төрийн албан хаагчдын тэмцээнийг 2024 онд зохион байгуулахыг хойшлуулж, 2025 онд зохион байгуулахаар шийдвэрлэсэн.	ҮБ	0
3	2.6.2. Хөвсгөл аймгийн ЗДТГ-тай "Санамж бичиг" байгуулж, туршлага судлах.	35.0 Дүүргийн төсөв	Харилцан туршлага судлах арга хэмжээний тоо	0	1	Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан тус арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон.	0	0

Зургаа. Цаашид анхаарах асуудал

1. Хэрэгжээгүй ажил, арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхой тусгах;
2. Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээ тус бүрийн хэрэгжих боломжит хугацааг тооцож, нарийвчлан (сараар) гаргах;
3. Шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг зөв тодорхойлж, төлөвлөх;
4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, хувийг бодитой тайлагнах;
5. Тайланг тогтоосон хугацаанд үнэн зөв, товч, тодорхой тайлагнах;


Долоо. Зөвлөмж

1. Дүүргийн Засаг даргын Тамгын газрын нийт албан хаагчдад Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалын 3 дугаар хавсралт "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг нэг бүрчлэн танилцуулж, хэрэгжүүлж ажиллах;
2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг гаргахдаа үр дүнг тооцсон, тоо баримтыг нэгтгэсэн арга хэмжээг хэмжих, үнэлэх үндэслэлтэй, хоёр мянган тэмдэгтэд багтаан хэрэгжилтийн явцыг товч тодорхой, үнэн бодитой тусгасан байх;
3. Нэгжийн дарга нар гүйцэтгэлийн тайлангийн хэрэгжилтэд анхаарч, төлөвлөгөөт ажлуудаа тогтоосон хугацаанд хэрэгжүүлж, хариуцсан албан хаагчийг үүрэгжүүлж, хяналт тавьж ажилладаг байх;

ТАНИЛЦСАН:
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

 Д. ТӨМӨРБААТАР

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА



С. ТУУЛМАА

БОЛОВСРУУЛСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН



Б. МӨНХТУЯА